



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 05

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Гурвансайхан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 18,500,000 /арван найман сая таван зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 2,826,390 /хоёр сая найман зуун хорин зургаан мянга гурван зуун ер/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Дуа 51-59 улсын дугаартай Уаз-31514 маркын автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөг, Хулд сумын ЭМТ-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13,440,000 /арван гурван сая дөрвөн зуун дөчин мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны үнээ нөхсөн Дуа 39-07 улсын дугаартай УАЗ-469 маркын автомашины худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая/ төгрөг болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 сарын 16-ний өдрийн “Хөрөнгө данснаас хасах тухай” 69 дугаар тогтоол, 2015 оны 12 сарын 30-ны өдрийн “Хөрөнгө данснаас хасах тухай” 90 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

Гурав. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дарьбумд үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0200115